



ГОЛОМТ БАНК

САНХҮҮ БАЙДАЛ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТУХАЙ УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ

“ГОЛОМТ БАНК ХК”

2025 ЖИЛИЙН ЭЦЭС

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Дараах удирдлагын хэлэлцүүлэг, шинжилгээг 2023, 2024 болон 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн сонгосон санхүүгийн болон үйл ажиллагааны үзүүлэлтүүд, мөн холбогдох санхүүгийн тайлан болон тэдгээрийн тайлбаруудтай хамтатган унших шаардлагатай. Эдгээр санхүүгийн тайланг “СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд энэ нь зарим талаар АНУ-ын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудаас (U.S. GAAP) ялгаатай байж болно. Энэхүү хэлэлцүүлэг нь ирээдүйд чиглэсэн мэдэгдлүүдийг агуулсан бөгөөд ирээдүйн үйл явдал, санхүүгийн гүйцэтгэлийн талаарх удирдлагын өнөөгийн байр суурь, хүлээлтийг илэрхийлнэ. Уг ирээдүйд чиглэсэн мэдэгдэлд дурдсан үр дүнгээс бодит үр дүн нь тодорхой таамаглах боломжгүй, баримт бичгийн бусад хэсэгт тодорхойлсон хүчин зүйлсийн нөлөөгөөр үлэмж хэмжээгээр зөрөх боломжтой.

АГУУЛГА

Хураангуй.....	3
Үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлс.....	3
Монгол улсын эдийн засаг	3
Өрсөлдөөн.....	3
Ханш болон хүүний түвшний өөрчлөлт.....	3
Зохицуулалтын орчин.....	4
Ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн сонгосон үзүүлэлтүүдийн тайлбар.....	4
Хүүгийн орлого	5
Хүүгийн зардал.....	5
Цэвэр хүүгийн орлого	6
Хүлээгдэж буй зээлийн алдагдал.....	6
Хураамж, шимтгэлийн орлого	6
Хураамж, шимтгэлийн зардал.....	6
Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал.....	6
Орлогын албан татварын зардал	7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	8
2025 оны үзүүлэлтийг 2024 онтой харьцуулахад	8
2024 оны үзүүлэлтийг 2023 онтой харьцуулахад	10
МӨНГӨН УРСГАЛ	13
Үйл ажиллагааны мөнгөн урсгал.....	13
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгал	14
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал	14
Хөрвөх чадвар.....	14
КАПИТАЛ ЗАРДАЛ	15
САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮД БОЛОН БАЛАНСЫН ГАДУУРХ ЗОХИЦУУЛАЛТУУД	15
Гадаад валют ба дериватив хэлцлүүд	15
Зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг	16
ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЛИЙН ТАЛААРХ ТООН БОЛОН ЧАНАРЫН МЭДЭЭЛЭЛ	16
Зээлийн эрсдэл.....	16
Зах зээлийн эрсдэл	16
Гадаад валютын ханшийн эрсдэл.....	17
Хүүний түвшний эрсдэл	17
Төлбөрийн чадварын эрсдэл.....	17
ИНФЛЯЦИЙН НӨЛӨӨ	17
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МАТЕРИАЛЛАГ БОДЛОГУУД	17
Санхүүгийн хөрөнгө.....	18
Орлого зардлын хүлээн зөвшөөрөлт.....	19
Гадаад валютын хөрвүүлэлт.....	20

Хураангуй

Бид Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банк, санхүүгийн үйлчилгээний тэргүүлэгч байгууллагуудын нэг бөгөөд корпорац, жижиг, дунд бизнес (“ЖДБ”) болон иргэдэд чиглэсэн арилжааны банкны өргөн хүрээний бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар манай нийт актив 19,182,928.9 сая төгрөг (5,393.5 сая ам.доллар), өөрийн хөрөнгө 1,685,659.5 сая төгрөг (473.9 сая ам.доллар) хүрч, Монгол Улсын томоохон банкуудын нэг хэвээр байна. Тайлант хугацааны эцэст бид 1.3 сая гаруй харилцагчтай байсан нь Монгол улсын нийт хүн амын ойролцоогоор 36%-ийг хамарч байгаа билээ.

Банкны хэмжээ, зах зээлд эзлэх байр суурь болон эдийн засагт үзүүлэх нөлөөг харгалзан бид дотоодын системийн нөлөө бүхий банк (D-SIB)-д тооцогддог бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, бидний дотоодын тайлан мэдээлэл, Монголбанк болон SWIFT-ийн тайланд үндэслэн Корпораци болон ЖДБ-ийн хадгаламж, зээлийн зах зээлд тус тус 25.8% болон 21.8%-ийн, аккредитивийн дүнгээр 60.6%-ийн, кастодиан банкны үйл ажиллагааны хүрээнд үйлчилж буй сангийн тоогоор 53.3%-ийн зах зээлийг эзэлж байна. Мөн иргэдийн сегментэд ипотекийн зээлд 23.6%, хэрэглээний зээлд 16.7%, кредит картын зээлд 39.2%, хадгаламжид 16.6%-ийн зах зээлийн эзлэх хувьтай байна. Нийт актив, зээл, хадгаламжаар зах зээлд эзлэх хувь тус тус 22.3%, 18.8% болон 20.6% байна. Манай төв оффис Улаанбаатар хотод байрладаг бөгөөд бүх үйл ажиллагаа Монгол Улсад төвлөрдөг. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 108 салбар (үүнээс 73 нь Улаанбаатар хотод, 35 нь орон нутагт), 403 АТМ болон CDM төхөөрөмжөөс бүрдсэн өргөн сүлжээгээр дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлж байна.

Үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлс

Банкны бизнес, үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдал нь дараах үндсэн хүчин зүйлсийн нөлөөнд өртөмтгий байдаг. Үүнд:

Монгол улсын эдийн засаг

Банкны санхүүгийн гүйцэтгэл нь бүх үйл ажиллагаагаа явуулдаг Монгол Улсын макро эдийн засгийн орчноос шууд хамааралтай. Дотоодын эдийн засгийн өсөлт, инфляц, макро эдийн засгийн бодлогын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс нь банкны үйл ажиллагаанд гол нөлөө үзүүлдэг бол валютын ханшийн хэлбэлзэл, гадаад валютын нөөц, хөрөнгийн урсгал, гадаад худалдааны хэмжээ зэрэг гадаад хүчин зүйлс нь үйл ажиллагааны орчныг тодорхойлоход чухал үүрэгтэй байдаг.

Монгол Улсын эдийн засаг цар тахлын дараах сэргэлтийг хадгалснаар бодит ДНБ-ий өсөлт 2022 онд 5.0%, 2023 онд 7.4%, 2024 онд 5.1%, 2025 онд ойролцоогоор 6.8% болжээ. 2025 оны өсөлт нь голчлон уул уурхайн салбарын идэвхтэй гүйцэтгэл, зэсийн олборлолтын мэдэгдэхүйц өсөлт, мөн өмнөх жилүүдийн цаг агаарын хүндрэлээс шалтгаалсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сэргэлтээс үүдэлтэй байсан байна. Мөн инфляц Монголбанкны зорилтот түвшинд хадгалагдсан бөгөөд хэрэглээний үнийн индексийн тогтворгүй бүрэлдэхүүн хэсгүүдийг хассан суурь инфляц нь мөнгөний хатуу бодлогын нөхцөлтэй уялдан буурах хандлагатай байлаа.

Гэсэн хэдий ч Монгол Улсын эдийн засаг нь түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай хэвээр байгаа тул дэлхийн зах зээлд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, эрэлтийн сулрал зэрэг гадаад шокт эмзэг хэвээр байна. Ийм нөхцөл байдал нь төлбөрийн тэнцэл болон төсвийн орлогод дарамт үзүүлж, улмаар макро эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулах боломжтой.

Өрсөлдөөн

Монголын санхүүгийн салбарын өрсөлдөөн эрс нэмэгдэж, 2025 оны байдлаар уг салбарт 12 арилжааны банк хийгээд зээл олголт, санхүүгийн зуучлалд идэвхтэй оролцон өргөжин тэлж буй банк бус санхүүгийн байгууллагууд (“ББСБ”) багтсан байна. Хэдийгээр ББСБ-ууд иргэдийн болон жижиг дунд бизнесийн зээлд идэвхтэй болсон ч банкны гол өрсөлдөөн нь санхүүгийн зах зээлийг давамгайлсаар байгаа арилжааны банкны салбарт хэвээр байгаа билээ.

Өрсөлдөөний гол хүчин зүйлс нь бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, бүтцийн өргөн цар хүрээ, брэндийн нэр хүнд, салбар сүлжээний хамрах хүрээ, дижитал болон мобайл үйлчилгээний чадавхи, үнийн стратеги,

мэдээллийн технологи ба эрсдэлийн удирдлагын системийн үр ашиг зэргээс хамаардаг. Үүний дээр Засгийн газрын тогтмол зохицуулалтын шинэчлэл, дижитал шилжилт, төрөлжсөн санхүүгийн бүтээгдэхүүний хүртээмж нэмэгдсэн нь салбарын орчин үеийн шинэчлэлийг хурдасгаж байна.

Банк болон ББСБ-уудаас ирж буй өрсөлдөөний хүчин зүйлсээс шалтгаалан банкны үнэ, санхүүжилтийн өртөг, зээлийн ахиуц ашигт дарамт үзүүлж, манай гол бизнес сегментүүдэд хэрэглэгч татах, хадгалах чадамжид нөлөөлж болзошгүй юм.

Хани болон хүүний түвшний өөрчлөлт

Банк гадаад валютын орлогыг гадаад валютын арилжаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас олдог бөгөөд энэхүү орлогын бодит үнэ цэнэ нь гадаад валютуудын дотоодын валют болох төгрөгтэй харьцуулах ханшийн хэлбэлзлээс шууд хамаардаг. Мөн банкны гадаад валютаарх хөрөнгө болон өр төлбөрийн үнэ цэнэ ханшийн хөдөлгөөнөөс хамааран үнэлгээний ашиг буюу алдагдал хүлээж болно. Ийм хэлбэлзэл нь банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, хөрөнгө, хөрөнгийн өгөөж, санхүүгийн эх үүсвэрийн хүртээмж, зардал болон хэрэглэгчийн санхүүгийн байдалд нөлөөлдөг.

Монгол Улс хөвөгч ханшийн тогтолцоотой бөгөөд төгрөгийн ханш нь макро эдийн засгийн нөхцөл байдал, гадаад секторын үзүүлэлт болон хөрөнгийн байр байдлаас хамаардаг. Сүүлийн 3 жилийн эцсээр нэг ам.доллартай тэнцэх төгрөгийн ханш 2023 онд 3,411 төгрөг, 2024 онд 3,420 төгрөг, 2025 онд ойролцоогоор 3,557 төгрөг байсан бөгөөд жилийн өөрчлөлт тус тус **-1.0%, 0.3% ба 4.0% байсан**. 2025 оны төгрөгийн сулралд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь эхний хагас жилийн нүүрсний үнийн бууралттай холбоотой экспортын орлогын бууралтаас болсон ба Монголын гадаад худалдааны тэнцэл нь нүүрсний үнэ, экспортын хэмжээнээс ихээхэн хамааралтай байдаг. Гэсэн хэдий ч нүүрсний үнэ тогтворжиж, нүүрс болон зэсийн экспортын хэмжээ нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал буурч, гадаад валютын нөөц нэмэгдсэнээр гадаад валютын албан нөөцийн нөхцөл байдал сайжирсан.

Төгрөгийн ханш огцом сулрах нь манай санхүүгийн байдалд ноцтой нөлөө үзүүлж болно. Хэрэв банк гадаад валютын өрийн нээлттэй позицтой байх үед валютын сулрал үүсвэл, валютын хөрвүүлгийн алдагдалд орж, өөрийн хөрөнгийн хүрэлцээ багасаж, нэмэлт хөрөнгө босгох шаардлага гарах аль эсвэл Монголбанкнаас тогтоосон зохицуулалтын шаардлагыг зөрчих эрсдэл үүснэ.

Банкны үйл ажиллагааны үр дүнгийн гол хүчин зүйл нь цэвэр хүүгийн орлого бөгөөд энэ нь одоогийн хүүгийн түвшин, хүү олдог хөрөнгө ба **хүү олдог** өр төлбөрийн бүтэц, хэмжээнээс шууд хамаардаг. Банкинд хэрэглэгдэж буй хүүгийн түвшин нь банкны хяналтаас гадуурх хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгддөг бөгөөд эдгээрт зохицуулалтын шинэчлэлүүд, дотоод болон дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал хийгээд өрсөлдөөний чиг хандлага нөлөөлдөг. 2025 оны 3-р сард Монголбанк бодлогын хүүг 10.0%-иас 12.0% болгон нэмсэн ба одоогоор энэ түвшинд хадгалж байна. Ирээдүйд бодлогын хүүг өөрчлөх тохиолдолд банкны хөрөнгөөс олох хүү, өр төлбөрийн үүргийн хүү болон цэвэр хүүгийн орлогод материаллаг хэмжээгээр шууд нөлөөлж болзошгүй юм.

Зохицуулалтын орчин

Монгол Улсын банкны салбарт үйлчилж буй төрийн зохицуулалт нь банкны бизнес, үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Иймд төрийн бодлого, Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулалтын орчны өөрчлөлт нь манай үйл ажиллагааны гүйцэтгэл, санхүүгийн үзүүлэлтүүдэд шууд нөлөөлдөг болно. Бид төрийн байгууллагуудын хяналт, зохицуулалтад өргөн хүрээнд хамрагддаг тул зээлийн үйл ажиллагааг дэмжих, хязгаарлах, өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг өөрчлөх, мөн банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор төрөөс бодлогын арга хэмжээг тухай бүр шинэчлэн хэрэгжүүлдэг билээ.

2025 онд эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний бодлогын нөхцөлийг чангатган бодлогын хүүг 10%-иас 12% хүртэл нэмэгдүүлж, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлэн төгрөгийн хадгаламжид 13%, гадаад валютын хадгаламжид 18%-ийг тогтоосон. Мөн өрхийн зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор өр, орлогын харьцаанд 50%-ийн хязгаар тогтоон чангаруулсан. Үүний зэрэгцээ тэтгэврийн орлогоор баталгаажсан зээлийг дэмжих зорилгод чиглэсэн зохицуулалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд үүнд заавал байлгах нөөцийн шаардлагад

хөнгөлөлт үзүүлэх, зээлийн ангиллыг өөрчлөхгүйгээр хугацааг хязгаарлагдмал хүрээнд сунгах боломж олгох, мөн холбогдох эрсдэлийн жинг 150%-аас 100% болгон бууруулах зэрэг багтсан.

Ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн сонгосон үзүүлэлтүүдийн тайлбар

Хүүгийн орлого

Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого

Хүүгийн орлого нь уламжлалт байдлаар банкны үйл ажиллагааны орлогын хамгийн том бүрэлдэхүүн хэсэг болж ирсэн. Бид харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, өрийн үнэт цаас, бусад банкуудад байршуулсан хөрөнгө, Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгө болон урвуу репо хэлцлийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргачлалаар тооцон тайлагнадаг. Доорх хүснэгтэд заасан хугацааны хүүгийн орлогыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	584,199.1	913,259.0	1,199,343.7	337.2
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	158,473.0	155,072.8	159,555.8	44.9
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад банкуудад байршуулсан хөрөнгө	25,015.8	12,287.3	8,412.6	2.4
Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгө	22,961.7	16,093.4	12,640.1	3.6
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаас	512.6	364.9	799.0	0.2
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх урвуу репо хэлцэл	1,547.9	2,153.3	1,942.2	0.5
	792,710.2	1,099,230.8	1,382,693.5	388.8

Бусад адилтгах орлого

Банкны бусад адилтгах орлогод бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас харьяалагдан тайлагнагддаг. Доорх хүснэгтэд заасан хугацааны бусад адилтгах орлогыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	24,155.7	28,172.7	27,009.2	7.6
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	23,866.7	35,785.6	65,892.9	18.5
	48,022.4	63,958.3	92,902.2	26.1

Хүүгийн зардал

Банкны хүүний зардал голчлон харилцагчдийн харилцах, хадгаламжинд төлсөн хүү, банкнаас гаргасан өрийн үнэт цаасны хүү, бусад зээл, бусад банкуудын байршуулсан хөрөнгийн хүү, репо хэлцлийн хүү, мөн түрээсийн хүүгийн зардал зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрддэг. Доорх хүснэгтэд заасан хугацааны хүүгийн зардлыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Харилцагчдын харилцах, хадгаламж .	271,817.9	426,993.3	597,444.3	168.0
Банкнаас гаргасан үнэт цаас	-	79,491.7	182,040.8	51.2
Зээлийн бусад эх үүсвэр	74,825.7	66,320.7	66,312.7	18.6
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	1,398.4	3,668.7	5,858.8	1.6
Репо хэлцэл	13,539.1	18,785.6	17,656.7	5.0
Түрээсийн хүүгийн зардал	1,859.4	3,308.6	5,046.7	1.4
	363,440.4	598,568.5	874,359.9	245.8

Цэвэр хүүгийн орлого

Цэвэр хүүгийн орлого нь хүүгийн орлогоос хүүгийн зардлыг хассан утга юм. Доорх хүснэгтэд заасан хугацааны цэвэр хүүгийн орлогыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Нийт хүүгийн орлого	840,732.6	1,163,189.1	1,475,595.6	414.9
Нийт хүүгийн зардал.....	(363,440.4)	(598,568.5)	(874,359.9)	(245.8)
Цэвэр хүүгийн орлого	477,292.1	564,620.6	601,235.7	169.0

Хүлээгдэж буй зээлийн алдагдал

Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаанд тооцсон хүлээгдэж буй зээлийн алдагдлын буцаалт эсвэл зардал нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Үүнд өмнө нь данснаас хассан зээлийн төлбөрийн эргэн төлөлт, зээлийн эрсдэлийн огцом өсөлт эсвэл бууралт, дефолт болох магадлалын өөрчлөлт, гадаад валютаарх хөрөнгийн ханшийн хэлбэлзэл болон бусад хөдөлгөөнүүд орно. Банкны хүлээгдэж буй зээлийн алдагдлын буцаалт нь 2023, 2024, 2025 онд тус тус 28,074.7 сая төгрөг, 5,521.8 сая төгрөг, 37,073.3 сая төгрөг (10.4 сая ам.доллар) дүнгэй байв.

Хураамж, шимтгэлийн орлого

Банкны хураамж, шимтгэлийн орлого нь карттай холбоотой шимтгэл, хураамж, гуйвуулгын ба бусад үйлчилгээний хураамж, баталгаа болон бусад баримтны үнэ, хураамж, дансны үйлчилгээний шимтгэл болон брокерийн үйлчилгээний хураамжаас бүрддэг. Доорх хүснэгтэд заасан хугацааны хураамж, шимтгэлийн орлогыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Карттай холбоотой шимтгэл, хураамж.....	56,561.2	69,769.0	81,778.8	23.0
Гуйвуулгын ба бусад үйлчилгээний хураамж.....	27,511.6	31,097.5	32,196.9	9.1
Баталгаа болон бусад баримтны үнэ, шимтгэл, хураамж	12,620.8	9,779.9	10,517.5	3.0
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж.....	5,142.1	5,429.4	5,766.9	1.6
Брокерийн болон бусад үйлчилгээний хураамж.....	335.3	9,345.8	12,914.4	3.6
	102,170.9	125,421.7	143,174.4	40.3

Хураамж, шимтгэлийн зардал

Банкны хураамж, шимтгэлийн зардал нь картын гүйлгээ, банкны үйлчилгээ, онлайн гүйлгээ болон брокерийн үйлчилгээний зардлаас бүрддэг. Доорх хүснэгтэд заасан хугацааны хураамж, шимтгэлийн зардлыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Картын гүйлгээний зардал.....	45,995.1	60,774.9	75,042.5	21.1
Банкны үйлчилгээний зардал	12,233.6	15,621.8	16,671.8	4.7
Онлайн гүйлгээний зардал	1,883.8	2,627.7	3,469.4	1.0
Брокерийн болон бусад үйлчилгээний зардал	77.9	580.9	489.4	0.1
	60,190.4	79,605.2	95,673.0	26.9

Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал

Банкны удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал голчлон (i) ажилчдын зардал буюу цалин, урамшуулал, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, ажилтны тэтгэмж, тэтгэврийн сан болон ажилтны сургалтын зардал; (ii) мэдээлэл, зөвлөх үйлчилгээ болон бусад мэргэжлийн үйлчилгээний зардал; (iii) үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал; (iv) ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал; (v) программ хангамж болон биет бус хөрөнгийн хорогдуулалт; (vi) зар сурталчилгаа, маркетингийн үйлчилгээ; (vii)

бичиг хэргийн зардал; (viii) харуул хамгалаалтын зардал; (ix) орлогын албан татвараас бусад татварын зардал; (x) зээлийн төлбөр цуглуулалтын зардал болон бусад зардлаас бүрддэг.

Доорх хүснэгтэд заасан хугацааны удирдлага ба үйл ажиллагааны бусад зардлыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023 (Сая төгрөг)	2024 (Сая төгрөг)	2025 (Сая ам.доллар)	
Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал:				
Ажилчдын зардал.....	84,251.9	117,286.1	138,179.2	38.9
Мэдээлэл, зөвлөх үйлчилгээ болон бусад мэргэжлийн үйлчилгээний зардал.....	34,057.7	52,114.0	54,603.4	15.4
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал.....	22,130.4	25,589.3	24,775.2	7.0
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал.....	6,890.5	9,166.5	12,536.4	3.5
Зар сурталчилгаа, маркетинг үйлчилгээ.....	5,308.5	6,985.3	11,233.1	3.2
Программ хангамж болон биет бус хөрөнгийн хорогдуулалт.....	6,368.8	8,824.5	9,675.9	2.7
Харилцагч татах зардал.....	5,923.6	7,080.4	8,506.7	2.4
Бичиг хэргийн зардал.....	4,192.8	4,376.1	5,476.7	1.5
Хандив.....	891.4	1,155.0	4,837.5	1.4
Харилцаа, холбооны зардал.....	2,853.0	3,903.1	4,726.7	1.3
Зээлийн төлбөр цуглуулалтын зардал.....	2,288.0	3,408.3	4,371.2	1.2
Харуул хамгаалалтын зардал.....	2,542.1	3,075.5	3,881.4	1.1
Оффис цэвэрлэгээний зардал.....	2,183.4	2,875.2	3,577.4	1.0
Ашиглалтын зардал.....	1,870.1	2,188.5	3,065.6	0.9
Орлогын албан татвараас бусад татварын зардал.....	3,183.7	2,401.2	2,953.5	0.8
Тээврийн зардал.....	2,050.5	2,284.2	2,922.4	0.8
Томилолтын зардал.....	1,566.1	2,099.6	2,362.7	0.7
Сайн дурын болон зайлшгүй даатгалын зардал.....	1,230.5	1,392.5	1,780.5	0.5
Үзвэр, үйлчилгээний зардал.....	1,577.0	2,230.7	1,727.0	0.5
Богино хугацаат түрээсийн зардал.....	1,428.6	1,296.7	832.7	0.2
Бусад зардал.....	7,370.5	10,933.3	11,233.1	3.2
Нийт удирдлага болон үйл ажиллагааны бусад зардал.....	200,159.3	270,665.8	313,258.5	88.1

Орлогын албан татварын зардал

Банкны орлогын албан татварын зардал нь тайлант жилийн орлогын албан татвар болон түр хугацааны зөрүүнээс үүдэлтэй холбоотой хойшлогдсон орлогын татварыг агуулдаг. СТОУС нягтлан бодох бүртгэлийн стандартууд болон Монгол улсын татварын хууль тогтоомжийн хоорондын ялгаатай байдал нь санхүүгийн тайлагналын зорилгоорх хөрөнгө, өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурь дүнгийн хооронд гарах түр зөрүүг үүсгэдэг. Доорх хүснэгтэд заасан хугацааны орлогын албан татварын зардлыг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023 (Сая төгрөг)	2024 (Сая төгрөг)	2025 (Сая ам.доллар)	
Тайлант жилийн орлогын албан татвар.....	98,112.7	92,128.1	48,258.2	13.6
Хойшлогдсон орлогын татвар.....	(41,248.6)	34,199.7	25,478.4	7.2
	56,864.1	126,327.8	73,736.7	20.7

Банк санхүүгийн тайлагналын зорилгоор орлогод суурилан албан татварыг тооцоолдог бөгөөд орлогын албан татварын зорилгоор татвар ногдохгүй орлого болон татвараас хасагдахгүй зардлын хувьд тохируулга хийх замаар орлогын албан татварын зардлыг тодорхойлдог. 2023, 2024, 2025 онд банкны орлогын албан татварын хувь хэмжээ эхний 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлогын 10%, харин уг дүнгээс дээш орлогод 25% байв.

Банкны үр ашигт орлогын албан татварын хувь хэмжээ 2023, 2024, 2025 онд тус тус 21.4%, 23.2%, болон 18.2% байлаа. 2024 оноос 2025 оны үр ашигт орлогын албан татварын хувь хэмжээ буурсан нь голчлон татвар ногдуулах ашиг буурсан, татвар ногдохгүй орлого нэмэгдсэн, бага хувиар татвар ногдуулах орлогын эзлэх хувь нэмэгдсэн, өмнө бүртгэгдээгүй хойшлуулсан татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн, татварын урамшуулал нэмэгдсэн болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал буурсан зэрэг хүчин зүйлс байв. Доорх хүснэгтэд хуулиар заасан хувиар тооцсон орлогын албан татварын зардлыг үр ашигт орлогын албан татварын хувь хэмжээнд нийцүүлэн тооцсон тайлбарыг заасан хугацаанд харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Татварын өмнөх ашиг	266,035.1	545,081.5	404,162.0	
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал 25%	66,508.8	136,270.4	101,040.5	28.4
Татварын зорилгоор татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардлын татварын нөлөө				
-Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө	(900.0)	(900.0)	(900.0)	(0.3)
-Татвараас чөлөөлөгдөх орлого.....	(3,858.4)	(11,201.0)	(15,325.0)	(4.3)
-Олон төрлийн хувь хэмжээгээр татвар ногдуулсны орлого	(851.2)	(646.1)	(4,043.4)	(1.1)
-Хасагдахгүй зардал.....	964.9	3,448.4	2,231.9	0.6
Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө.....	(5,000.0)	-	(4,444.9)	(1.2)
Татварын хөнгөлөлтийн нөлөө.....	-	(643.9)	(4,822.5)	(1.4)
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	56,864.1	126,327.8	73,736.7	20.7

Банкны тайлант жилийн цэвэр ашиг 2023, 2024, 2025 онд тус тус 209,171.0 сая төгрөг, 418,753.7 сая төгрөг, 330,425.4 сая төгрөг байв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2025 оны үзүүлэлтийг 2024 онтой харьцуулахад

Хүүгийн орлого

Банкны үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого 2025 онд 25.8%-иар өсөж, 2024 оны 1,099,230.8 сая төгрөгөөс 1,382,639.5 сая төгрөгт (388.7 сая ам.доллар) хүрсэн. Энэхүү өсөлт нь голчлон харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтаас олох хүүгийн орлого нэмэгдсэнтэй холбоотой.

Банкны бусад адилтгах орлого 2025 онд 45.3%-иар өсөж, 2024 оны 63,958.3 сая төгрөгөөс 92,902.2 сая төгрөг (26.1 сая ам.доллар) болсон нь голчлон 30,107.3 сая төгрөг бүхий бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаастай холбоотой.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүүгийн орлого 2025 онд 31.3%-иар нэмэгдэж, 2024 оны 913,259.0 сая төгрөгөөс 1,199,343.7 сая төгрөгт (337.2 сая ам.доллар) хүрсэн нь голчлон нийт зээлийн багцын өсөлт болон Монголбанкны бодлогын хүү чангарсны улмаас дундаж зээлийн хүү нэмэгдсэнтэй холбоотой.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хүүгийн орлого

Банкны бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хүүгийн орлого 2024 оны 155,072.8 сая төгрөгөөс 2.9%-иар нэмэгдэн 2025 онд 159,555.8 сая төгрөгт (44.9 сая ам.доллар) хүрсэн нь нийт бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны багц 2024 оны 2,290,916.4 сая төгрөгөөс 2025 онд 2,764,200.5 сая төгрөг болж өссөнтэй холбоотой бөгөөд үүнд Монголбанкны үнэт цаасны эзэмшил нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад банкуудад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад банкуудад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого 2025 онд 31.5%-иар буурч, 2024 оны 12,287.3 сая төгрөгөөс 8,412.6 сая төгрөг (2.4 сая ам.доллар) болсон. Энэхүү бууралт нь голчлон олон улсын банкуудад байршуулсан хөрөнгийн хэмжээ буурсантай холбоотой.

Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгөний хүүгийн орлого

Банкны Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгөний хүүгийн орлого 2025 онд 21.5%-иар буурч, 2024 оны 16,093.4 сая төгрөгөөс 12,640.1 сая төгрөг (3.6 сая ам.доллар) болсон. Энэхүү бууралт нь Монголбанкнаас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр заавал байлгах нөөцийн урамшууллын хөтөлбөрийг зогсоосонтой холбоотой.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасаарх хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасны хүүний орлого 2025 онд 119.0%-иар өсөж, 2024 оны 364.9 сая төгрөгөөс 799.0 сая төгрөг (0.2 сая ам.доллар) болсон. Энэхүү өсөлт нь 2024 онд худалдан авсан үнэт цааснуудыг 2025 онд илүү удаан хугацаанд эзэмшсэн, мөн 2025 онд шинээр худалдан авч, тус ондоо худалдсан үнэт цааснаас үүссэн хүүний орлоготой холбоотой.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх урвуу репо хэлцлийн хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх урвуу репо хэлцлийн хүүгийн орлого 2025 онд 9.8%-иар буурч, 2024 оны 2,153.3 сая төгрөгөөс 1,942.2 сая төгрөг (0.5 сая ам.доллар) болсон. Энэхүү бууралт нь урвуу репо хэлцлийн хэмжээ буурсантай холбоотой.

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон, зээл ба урьдчилгааны бусад адилтгах орлого

Банкны бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон, зээл ба урьдчилгааны бусад адилтгах орлого 2025 онд 4.1%-иар буурч, 2024 оны 28,172.7 сая төгрөгөөс 27,009.2 сая төгрөг (7.6 сая ам.доллар) болсон. Уг бууралт нь бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон, зээл ба урьдчилгааны нийт зээлийн багц багассантай холбоотой.

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх бусад адилтгах орлого

Банкны бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэ цаасаарх бусад адилтгах орлого 2025 онд 84.1%-иар өсөж, 2024 оны 35,785.6 сая төгрөгөөс 65,892.9 сая төгрөгт (18.5 сая ам.доллар) хүрсэн. Энэхүү өсөлтөд голчлон бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэ цаасны багцын өсөлт нөлөөлсөн бөгөөд үүнд Монголын Ипотекийн Корпорациас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас болон Засгийн газрын бондын эзэмшил багтана.

Хүүгийн зардал

Банкны хүүгийн зардал 2025 онд 46.1%-иар өсөж, 2024 оны 598,568.5 сая төгрөгөөс 874,359.9 сая төгрөг (245.8 сая ам.доллар) болсон. Уг өсөлт нь голчлон харилцагчдийн хадгаламжийн хүүгийн зардал нэмэгдсэн, банкны гаргасан өрийн үнэт цааснаас бүрдсэн санхүүжилтийн өртөг ихэссэнтэй холбоотой.

Харилцагчдын харилцах, хадгаламжийн хүүгийн зардал

Банкны харилцагчдын харилцах, хадгаламжийн хүүгийн зардал 2025 онд 39.9%-иар өсөж, 2024 оны 426,993.3 сая төгрөгөөс 597,444.3 сая төгрөг (168.0 сая ам.доллар) болсон. Энэхүү өсөлт нь тайлант жилд хугацаат хадгаламжийн хэмжээ ихээр нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд үүнийг хадгаламжийн харилцагчдийг татах идэвхжүүлэлтийн ажлууд нөлөөлсөн.

Банкнаас гаргасан үнэт цаасны хүүгийн зардал

Банкны банкнаас гаргасан үнэт цаасны хүүгийн зардал 2025 онд 129%-иар 2024 оны 79,491.7 сая төгрөгөөс 182,040.8 сая төгрөг (51.2 сая ам.доллар) болсон. Энэхүү өсөлт нь 2025 онд 50 сая ам.долларын Тогтвортой санхүүжилтийн бонд болон 15,000 сая иений Самурай бондыг гаргасантай холбоотой.

Зээлийн бусад эх үүсвэрийн хүүгийн зардал

Банкны зээлийн бусад эх үүсвэрийн хүүгийн зардал 2025 онд 0.01%-иар буурч, 2024 оны 66,320.7 сая төгрөгөөс 66,312.7 сая төгрөг (18.6 сая ам.доллар) болсон. Энэхүү бууралтыг голчлон Засгийн газрын өрийн үнэт цаасны зээлжих зэрэглэлийг сайжруулсантай холбоотой бөгөөд үүний улмаар гадаадын банкууд болон санхүүгийн байгууллагаас авах зээлийн өртөг буурсан. Энэ нь зээлийн нийт хэмжээ өссөн ч хүүгийн зардлыг тогтвортой хадгалахад нөлөөлсөн.

Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн хүүгийн зардал

Банкны бусад банкуудын байршуулсан хөрөнгийн хүүгийн зардал 2025 онд 59.7%-иар өсөж, 2024 оны 3,668.7 сая төгрөгөөс 5,858.8 сая төгрөг (1.6 сая ам.доллар) болсон. Энэхүү өсөлт нь дотоодын банк хоорондын хадгаламжийн гүйлгээ ихэссэнтэй холбоотой.

Репо хэлцлийн хүүгийн зардал

Банкны репо хэлцлийн хүүгийн зардал 2025 онд 6.0%-иар буурч, 2024 оны 18,785.6 сая төгрөгөөс 17,656.7 сая төгрөг (5 сая ам.доллар) болсон бөгөөд үүний үндсэн шалтгаан нь жилийн турш дундаж репо хүүгийн бууралт болон/эсвэл гүйлгээний хугацаатай холбоотой юм.

Түрээсийн зардлын бусад адилтгах зардал

Банкны түрээсийн хүүний зардал 2025 онд 52.5%-иар өсөж, 2024 оны 3,308.6 сая төгрөгөөс 5,046.7 сая төгрөг (1.4 сая ам.доллар) болсон бөгөөд үүний гол шалтгаан нь түрээсийн төлбөрийн өсөлт болон түрээсийн гэрээг шинэчилж, түрээсийн хураамжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

Цэвэр хүүгийн орлого

Эдгээр үзүүлэлтүүдийн үр дүнд, банкны 2025 оны цэвэр хүүгийн орлого 601,235.7 сая төгрөг (169.0 сая ам.доллар) болж, 2024 оны 564,620.6 сая төгрөгөөс 6.5%-иар нэмэгдсэн.

Хураамж, шимтгэлийн орлого

Банкны хураамж, шимтгэлийн орлого 2025 онд 14.2%-иар өсөж, 2024 оны 125,421.7 сая төгрөгөөс 143,174.4 сая төгрөг (40.3 сая ам.доллар) болсон бөгөөд үүний гол шалтгаан нь шинэ картын бүтээгдэхүүнүүдийг гаргаснаас үүдэн пластик картын гүйлгээнд ногдох шимтгэл, брокер болон бусад үйлчилгээний шимтгэл нэмэгдсэн явдал юм.

Хураамж, шимтгэлийн зардал

Банкны хураамж, шимтгэлийн зардал 2025 онд 20.2%-иар өсөж, 2024 оны 79,605.2 сая төгрөгөөс 95,673.0 сая төгрөг (26.9 сая ам.доллар) болсон бөгөөд үүний үндсэн шалтгаан нь пластик картын гүйлгээний шимтгэл болон цахим гүйлгээний зардлын өсөлт байв.

Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал

Банкны удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал 2025 онд 15.7%-иар өсөж, 2024 оны 270,665.8 сая төгрөгөөс 313,258.5 сая төгрөг (88.1 сая ам.доллар) болсон бөгөөд үүнд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь ажилтны цалин, урамшуулалтай холбоотой зардлын өсөлт болон ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардлын нэмэгдэл байв. Энэхүү өсөлт нь түрээсийн хүүгийн зардлын өсөлттэй уялдаж байна.

Орлогын албан татварын зардал

Банкны орлогын албан татварын зардал 2025 онд 41.6%-иар буурч, 2024 оны 126,327.8 сая төгрөгөөс 73,736.7 сая төгрөг (20.7 сая ам.доллар) болсон бөгөөд бууралтад голлон нөлөөлсөн хүчин зүйл нь татварын өмнөх ашиг буурсан болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуух татварын урамшууллын нэмэгдэл байв.

Жилийн ашиг

Эдгээр үзүүлэлтийн үр дүнд банкны жилийн ашиг 2025 онд 21.1%-иар буурч, 2024 оны 418,753.7 сая төгрөгөөс 330,425.4 сая төгрөг (92.9 сая ам.доллар) болсон байна.

2024 оны үзүүлэлтийг 2023 онтой харьцуулахад

Хүүгийн орлого

Банкны үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого 2024 онд 38.7%-иар өсөж, 2023 оны 792,710.2 сая төгрөгөөс 1,099,230.8 сая төгрөгт хүрсэн. Энэхүү өсөлт нь голчлон харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа 329,060.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Банкны бусад адилтгах орлого 2024 онд 33.2%-иар өсөж, 2023 оны 48,022.4 сая төгрөгөөс 63,958.3 сая төгрөг болсон нь голчлон бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон, зээл ба урьдчилгааны бусад адилтгах орлого 4,017.0 сая төгрөгөөр, бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх бусад адилтгах орлого 11,918.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүүгийн орлого 2024 онд 56.3%-иар нэмэгдэж, 2023 оны 584,199.1 сая төгрөгөөс 913,259.1 сая төгрөгт хүрсэн нь голчлон нийт бизнесийн сегментийг хамарсан зээлийн багцийн огцом өсөлттэй холбоотой.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хүүгийн орлого

Банкны бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хүүгийн орлого 2023 оны 158,473.0 сая төгрөгөөс 2.1%-иар буурч 2024 онд 155,072.8 сая төгрөгт хүрсэн нь өрийн үнэт цаасны купоны хэмжээ буурсантай холбоотой.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад банкуудад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад банкуудад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого 2024 онд 50.9%-иар буурч, 2023 оны 25,015.8 сая төгрөгөөс 12,287.3 сая төгрөг болсон. Энэхүү бууралт нь голчлон олон улсын банкууд дахь хөрөнгө байршуулалтын хэмжээ буурсантай холбоотой.

Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгөний хүүгийн орлого

Банкны Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгөний хүүгийн орлого 2024 онд 29.9%-иар буурч, 2023 оны 22,961.7 сая төгрөгөөс 16,093.4 сая төгрөг болсон. Энэхүү бууралт нь Монголбанкаас заавал байлгах нөөцийн урамшууллын хөтөлбөрийг зогсоосонтой холбоотой.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасаарх хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасны хүүний орлого 2024 онд 28.8%-иар буурч, 2023 оны 512.6 сая төгрөгөөс 364.9 сая төгрөг болсон. Энэхүү бууралт нь хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасны дундаж үлдэгдэл багассантай холбоотой.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх урвуу репо хэлцлийн хүүгийн орлого

Банкны хорогдуулсан өртгөөр хэмжигдэх урвуу репо хэлцлийн хүүгийн орлого 2024 онд 39.1%-иар өсөж, 2023 оны 1,547.9 сая төгрөгөөс 2,153.3 сая төгрөг болсон. Энэхүү өсөлт нь урвуу репо хэлцлийн тоо хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон, зээл ба урьдчилгааны бусад адилтгах орлого

Банкны бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон, зээл ба урьдчилгааны бусад адилтгах орлого 2024 онд 16.6%-иар өсөж, 2023 оны 24,155.7 сая төгрөгөөс 28,172.7 сая төгрөг болсон. Уг өсөлт нь бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон, зээл ба урьдчилгааны нийт зээлийн багц нэмэгдсэнтэй холбоотой.

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх бусад адилтгах орлого

Банкны бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх бусад адилтгах орлого 2024 онд 49.9%-иар өсөж, 2023 оны 23,866.7 сая төгрөгөөс 35,785.6 сая төгрөгт хүрсэн. Энэхүү

өсөлтөд голчлон бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны багцын өсөлт нөлөөлсөн.

Хүүгийн зардал

Банкны хүүгийн зардал 2024 онд 64.7%-иар өсөж, 2023 оны 363,440.4 сая төгрөгөөс 598,568.5 сая төгрөг болсон. Уг өсөлт нь голчлон харилцагчдийн хадгаламжийн хүүгийн зардал 155,175.4 сая төгрөгөөр, банкны гаргасан өрийн үнэт цаасны хүүгийн төлөлт 79,491.7 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Харилцагчдын харилцах, хадгаламжийн хүүгийн зардал

Банкны харилцагчдын харилцах, хадгаламжийн хүүгийн зардал 2024 онд 57.1%-иар өсөж, 2023 оны 271,817.9 сая төгрөгөөс 426,993.3 сая төгрөг болсон. Энэхүү өсөлт нь тайлант жилд хугацаат хадгаламжийн хүү төлөлт нэмэгдсэнтэй холбоотой.

Банкнаас гаргасан үнэт цаасны хүүгийн зардал

Банкны банкнаас гаргасан үнэт цаасны хүүгийн зардал 2024 онд 100%-иар 2023 оноос нэмэгдэн 79,491.7 сая төгрөгт хүрсэн. Энэхүү өсөлт нь доллараар нэрлэсэн олон улсын бондын шинэ гаргалт болон нэмэлт гаргалт хийсэнтэй холбоотой юм.

Зээлийн бусад эх үүсвэрийн хүүгийн зардал

Банкны зээлийн бусад эх үүсвэрийн хүүгийн зардал 2024 онд 11.4%-иар буурч, 2023 оны 74,825.7 сая төгрөгөөс 66,320.7 сая төгрөг болсон. Энэхүү бууралтыг голчлон Засгийн газрын өрийн үнэт цаасны зээлжих зэрэглэлийг сайжруулсантай холбоотой бөгөөд үүний улмаар гадаадын банкууд болон санхүүгийн байгууллагаас авах зээлийн өртөг буурсан.

Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн хүүгийн зардал

Банкны бусад банкуудын байршуулсан хөрөнгийн хүүгийн зардал 2024 онд 162.4%-иар өсөж, 2023 оны 1,398.4 сая төгрөгөөс 3,668.7 сая төгрөг болсон. Энэхүү өсөлт нь дотоодын банк хоорондын хадгаламжийн гүйлгээний ихэссэнтэй холбоотой.

Репо хэлцлийн хүүгийн зардал

Банкны репо хэлцлийн хүүгийн зардал 2024 онд 38.8%-иар өсөж, 2023 оны 13,539.1 сая төгрөгөөс 18,785.6 сая төгрөг болсон бөгөөд үүний үндсэн шалтгаан нь баланс дахь репо хэлцлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

Түрээсийн зардлын бусад адилтгах зардал

Банкны түрээсийн хүүний зардал 2024 онд 77.9%-иар өсөж, 2023 оны 1,859.4 сая төгрөгөөс 3,308.6 сая төгрөг болсон бөгөөд үүний гол шалтгаан нь түрээсийн төлбөрийн өсөлт болон түрээсийн хураамжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

Цэвэр хүүгийн орлого

Эдгээр үзүүлэлтүүдийн үр дүнд, банкны 2024 оны цэвэр хүүгийн орлого 564,620.6 сая төгрөг болж, 2023 оны 477,292.1 сая төгрөгөөс 18.3%-иар нэмэгдсэн.

Хураамж, шимтгэлийн орлого

Банкны хураамж, шимтгэлийн орлого 2024 онд 22.8%-иар өсөж, 2023 оны 102,170.9 сая төгрөгөөс 125,421.7 сая төгрөг болсон бөгөөд үүний гол шалтгаан нь шинэ картын бүтээгдэхүүнүүдийг гаргаснаас үүдэн пластик картын гүйлгээнд ногдох шимтгэл 13,207.8 сая төгрөгөөр, брокер болон бусад үйлчилгээний шимтгэл 9,010.5 сая төгрөгөөр нэмэгдсэн явдал юм.

Хураамж, шимтгэлийн зардал

Банкны хураамж, шимтгэлийн зардал 2024 онд 32.3%-иар өсөж, 2023 оны 60,190.4 сая төгрөгөөс 79,605.2 сая төгрөг болсон бөгөөд үүний үндсэн шалтгаан нь пластик картын гүйлгээний шимтгэл болон цахим гүйлгээний зардлын өсөлт байв.

Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал

Банкны удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал 2024 онд 35.2%-иар өсөж, 2023 оны 200,159.3 сая төгрөгөөс 270,665.8 сая төгрөг болсон бөгөөд үүнд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь өндөр инфляциас үүдсэн ажилтны цалин, урамшуулалтай холбоотой зардлын өсөлт болон олон улсын бонд гаргалттай холбоотой мэдээлэл, зөвлөх үйлчилгээ болон бусад мэргэжлийн үйлчилгээний зардлын өсөлтүүд байв.

Орлогын албан татварын зардал

Банкны орлогын албан татварын зардал 2024 онд 122.2%-иар өсөж, 2023 оны 56,864.1 сая төгрөгөөс 126,327.8 сая төгрөг болсон бөгөөд өсөлтөнд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь татварын өмнөх ашиг нэмэгдсэнтэй холбоотой.

Жилийн ашиг

Эдгээр үзүүлэлтийн үр дүнд банкны жилийн ашиг 2024 онд 100.2%-иар өсөж, 2023 оны 209,171.0 сая төгрөгөөс 418,753.7 сая төгрөг болсон байна.

МӨНГӨН УРСГАЛ

Банкны үйл ажиллагааны түүхэн хугацаанд мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хувьцаа ээмшигчдийн санхүүжилт, банкуудын зээл, ам.доллараар нэрлэсэн бонд болон үйл ажиллагааны мөнгөн урсгалаас бүрдэж ирсэн. Банк богино болон урт хугацааны төлбөрийн чадварын шаардлагыг хангах зорилгоор өнөөгийн болон ирээдүйн хөрвөх чадварын хэрэгцээ, зээлийн гэрээний нөхцөлүүд болох ковенантуудын хэрэгжилтийг тогтмол хянаж, шаардлагатай мөнгөн хөрөнгийн нөөцийг хадгалахыг зорьдог. Банкин дахь санхүүгийн эх үүсвэрүүд болох өдөр тутмын үйл ажиллагаанаас бий болох мөнгөн урсгал хийгээд цэвэр орлогыг харгалзан үзэхэд ойрын 12 сарын хугацаанд эргэлтийн хөрөнгө болон үйл ажиллагааны хэрэгцээг бүрэн хангах төлбөрийн чадвартай байна.

Доорх хүснэгтэд заасан хугацааны мөнгөн урсгалын мэдээллийг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,316,553.4	(244,138.3)	448,906.7	126.2
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(650,747.5)	207,844.0	(59,993.3)	(16.9)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	83,969.9	2,034,063.4	1,487,048.7	418.1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	(40,553.0)	(25,571.2)	(44,757.9)	(12.6)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт /(бууралт)	709,222.8	1,972,197.9	1,831,204.2	514.9
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,275,414.5	2,984,637.3	4,956,835.2	1,393.7
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,984,637.3	4,956,835.2	6,788,039.4	1,908.5

Үйл ажиллагааны мөнгөн урсгал

Банк 2025 оны үйл ажиллагаанаас нийт 448,906.7 сая төгрөгийн цэвэр мөнгөн урсгалыг бий болгосон. Уг мөнгөн урсгал нь тухайн жилийн 404,162.0 сая төгрөгийн (113.6 сая ам.доллар) татварын өмнөх ашгаас үүссэн бөгөөд үүнд голчлон харилцагчдын харилцах хадгаламжийн цэвэр өсөлт болох 1,250,219.7 сая төгрөг (351.5 сая ам.доллар) эерэгээр нөлөөлсөн боловч харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны 1,283,866.7 сая төгрөгийн өсөлт (361.0 сая ам.доллар) уг нөлөөг саармагжуулсан.

2024 оны үйл ажиллагааны хүрээнд банк нийт 244,138.3 сая төгрөгийн цэвэр мөнгөн урсгалын зарцуулалт бүртгэсэн бөгөөд энэ нь 545,081.5 сая төгрөгийн татварын өмнөх ашгийг үл харгалзан зээлийн багц огцом тэлж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа 2,817,708.8 сая төгрөгөөр өссөнтэй холбоотойгоор мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлсөн. Харин харилцагчдын харилцах, хадгаламж 1,289,197.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь уг нөлөөг тодорхой хэмжээнд бууруулсан.

2023 онд банк үйл ажиллагаанаас 1,316,553.4 сая төгрөгийн цэвэр мөнгөн урсгал бий болгосон бөгөөд энэ нь 266,035.1 сая төгрөгийн татварын өмнөх ашиг, мөн харилцагчдын харилцах, хадгаламж 2,250,057.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой. Харин үүнийг харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа 1,222,173.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хэсэгчлэн бууруулсан.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгал

Банк 2025 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 59,993.3 сая төгрөгийн (16.9 сая ам.доллар) цэвэр мөнгөн урсгалын зарцуулалтыг хийсэн байна. Уг зарцуулалтанд голчлон эргэлтийн бус хөрөнгийн урьдчилгаа болох 65,751.3 сая төгрөг (18.5 сая ам.доллар), бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өмчийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт бүхий 34,371.3 сая төгрөг (9.7 сая ам.доллар) болон 38,999.5 сая төгрөгийн (11.0 сая ам.доллар) үндсэн хөрөнгийн худалдан авалтаар тайлбарлагдан бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого буюу 107,420.9 сая төгрөгийн (30.2 сая ам.доллар) орох мөнгөн урсгалаар хэсэгчлэн нөхөгдсөн байна.

2024 онд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас 207,844.0 сая төгрөгийн цэвэр мөнгөн урсгал бий болсон нь голчлон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлогоос 512,775.7 сая төгрөг бий болсонтой холбоотой бөгөөд бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт бүхий 209,067.9 сая төгрөгийн дүнгийн зарцуулалт хийснээр буурсан.

2023 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 650,747.5 сая төгрөгийн цэвэр мөнгөн урсгалын зарцуулалт хийгдсэн ба үүнд голчлон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт бүхий 843,094.4 сая төгрөг болон эргэлтийн бус хөрөнгийн урьдчилгааны 176,045.2 сая төгрөг нөлөөлж бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого буюу 390,779.3 сая төгрөгөөр хэсэгчлэн нөхөлт хийгдсэн.

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал

2025 онд санхүүгийн үйл ажиллагаанаас 1,487,048.7 сая төгрөгийн (418.1 сая ам.доллар) цэвэр мөнгөн урсгал бий болсон. Энэ нь голчлон репо хэлцлээс 8,019,984.2 сая төгрөг (2,254.9 сая ам.доллар) төвлөрүүлж, өрийн үнэт цаас гаргаснаас 551,196.5 сая төгрөг (155.0 сая ам.доллар) татан төвлөрүүлсэнтэй холбоотой бөгөөд репо хэлцлийн эргэн төлөлтөд 7,156,623.4 сая төгрөг (2,012.2 сая ам.доллар) зарцуулснаар хэсэгчлэн буурсан.

2024 онд санхүүгийн үйл ажиллагаанаас 2,034,063.4 сая төгрөгийн цэвэр мөнгөн урсгал бий болсон нь репо хэлцлээс 4,683,254.7 сая төгрөг, өрийн үнэт цаас гаргалтаас 1,337,438.1 сая төгрөг татан төвлөрүүлсэнтэй холбоотой бөгөөд репо хэлцлийн эргэн төлөлтөд 3,853,776.3 сая төгрөг зарцуулснаар хэсэгчлэн буурсан.

2023 онд санхүүгийн үйл ажиллагаанаас 83,969.9 сая төгрөгийн цэвэр мөнгөн урсгал бий болсон нь репо хэлцлээс 4,097,128.1 сая төгрөг татан төвлөрүүлсэнтэй холбоотой бөгөөд репо хэлцлийн эргэн төлөлтөд 3,586,092.5 сая төгрөг зарцуулснаар хэсэгчлэн буурсан.

Хөрвөх чадвар

Банк зээл болон хөрөнгө оруулалтын багцаа голчлон харилцагчдын хадгаламж, бусад банк санхүүгийн байгууллагуудаас татсан эх үүсвэр болон Монголбанкнаас авсан санхүүжилтээр санхүүжүүлдэг билээ. Харилцагчдын хадгаламж нь банкны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр байсаар ирсэн ба цаашид ч хэвээр хадгалагдана гэж үзэж байгаа бөгөөд 2023, 2024, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1 жилээс доош хугацаатай хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь хэмжээ тус тус 98.56%, 98.92%, 98.95%-тай байна.

БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ

Монголбанк нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх банкуудын өөрийн хөрөнгийн шаардлагыг тогтмол хянаж, зохицуулдаг. Монголбанкнаас банкуудын эрсдэлээр жинлэсэн хөрөнгөнд суурилсан өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод түвшинг тогтоодог бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар энэхүү доод түвшин 12.0%-д байсан. Голомт банк Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг бүрэн хангаж ажилласан ба банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 2023, 2024, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус тус 15.9%, 14.7%, 15.3% байсан нь зохистой байдлын шалгуур үзүүлэлтийн шаардлагаас дээгүүр түвшинд хадгалагдаж байгааг харуулж байна.

Доорх хүснэгтэд заасан хугацааны өөрийн хөрөнгийн бүтцийн мэдээллийг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар		
	2023	2024	2025
	(Сая төгрөг)		
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө:			
Энгийн хувьцаа	202,164.3	202,164.3	202,164.3
Нэмж төлөгдсөн капитал	301,481.1	301,481.1	301,481.1
Хуримтлагдсан ашиг	436,232.3	753,884.3	1,031,152.4
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	230.8	577.6	544.3
Халаасны хувьцаа.....	-	-	-
Нийт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	940,108.5	1,258,107.3	1,535,342.2
Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө:			
Давуу эрхтэй хувьцаа.....	-	-	-
Халаасны хувьцаа/давуу эрхийн хувьцаа	-	-	-
Нийт хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө	-	-	-
Нийт өөрийн хөрөнгө.....	940,108.5	1,258,107.3	1,535,342.2
Нэгдүгээр зэрэглэлийн хүрэлцээний үзүүлэлт.....	15.86%	14.67%	15.34%
Эрсдэлээр жинлэсэн активын харьцаа	15.86%	14.67%	15.34%

КАПИТАЛ ЗАРДАЛ

Банкны капитал зардлууд 2023, 2024, 2025 онуудад тус тус 210,898.0 сая төгрөг, 98,138.5 сая төгрөг, 110,008.0 сая төгрөг байсан бөгөөд голчлон бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, салбарын тоо болон ажилтны тоог нэмэгдүүлэх, шинэ оффисын барилга байгуулахтай уялдан оффисын барилга, түрээсийн сайжруулалт, албан тасалгааны тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн худалдан авалтад чиглэсэн.

САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮД БОЛОН БАЛАНСЫН ГАДУУРХ ЗОХИЦУУЛАЛТУУД

Гадаад валют ба дериватив хэлцлүүд

Банк харилцагчдын хэрэгцээ, өөрсдийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагын зорилгоор гадаад валютын арилжаа болон дериватив хэлцлүүдийг гүйцэтгэдэг. Банкны гадаад валютын хэлцэлд форвард ханшийн гэрээ болон валютын своп хэлцлүүд багтдаг. Банк Монголбанктай 2018 оноос 2025 оны хооронд урт хугацааны валютын хүүгийн своп хэлцэл байгуулан ажиллаж, уг хэлцэлтэй холбоотой санхүү хөрөнгийг 2023, 2024, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус тус 199,496.0 сая төгрөг, 234,775.3 сая төгрөг, 235,561.1 сая төгрөгөөр (66.2 сая ам.доллар) бүртгэсэн.

Доорх хүснэгтэд заасан хугацааны гадаад валютын фовард болон своп хэлцлийн дүнг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			
	2023	2024	2025	
			(Сая төгрөг)	(Сая ам.доллар)
Гадаад валютын форвард болон своп хэлцлийн бодит үнэ цэнэ	(Сая төгрөг)	(Сая төгрөг)		
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө	202,386.9	235,680.0	260,415.1	73.2
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн өр төлбөр	(2,890.9)	(904.7)	(24,854.0)	(7.0)
Гадаад валютын форвард болон своп хэлцлийн цэвэр бодит үнэ цэнэ ..	199,496.0	234,775.3	235,561.1	66.2

Зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Эдгээр зээлтэй холбоотой үйлчилгээний хүрээнд банк баталгаа эсхүл аккредитивийн дүн, мөн тухайн харилцагчийн зээлийн эрсдэлийн түвшинг харгалзан шимтгэл авдаг. Аккредитив нь харилцагчдын зээлийн чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Баталгаа нь харилцагч санхүүгийн эсхүл гүйцэтгэлийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд банк өмнөөс нь төлбөрийг барагдуулах гэсэн цуцлагдах боломжгүй амлалтыг илэрхийлдэг. Санхүүгийн баталгаа нь харилцагч тодорхой санхүүгийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд банк гуравдагч этгээдэд төлбөр хийх үүрэг хүлээсэн амлалт бол гүйцэтгэлийн баталгаа нь харилцагч санхүүгийн бус гэрээт үүргээ биелүүлээгүй нөхцөлд банк гуравдагч этгээдэд төлбөр хийх үүргийг илэрхийлнэ. Банк зээл олгохоор хүлээсэн үүргүүдтэй бөгөөд энэ нь зээл, баталгаа, кредит картын лимит эсвэл аккредитивын хэлбэрээр үүсгэсэн зээлийн шугамын ашиглагдаагүй хэсгийг илэрхийлж байдаг. Доорх хүснэгтэд заасан хугацааны баталгаа болон бичиг баримтын төлбөрийн хэрэгслийн дүнг харуулсан болно:

	Жилийн эцэс 12 сарын 31-ий байдлаар			(Сая ам.доллар)
	2023	2024	2025	
	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	(Сая төгрөг)	
Банкны баталгаа:				
Олгосон санхүүгийн баталгаа.....	67,082.0	102,351.9	104,344.0	29.3
Олгосон гүйцэтгэлийн баталгаа.....	386,870.7	422,916.4	603,233.8	169.6
Бичиг баримтын төлбөрийн хэрэгсэл:				
Аккредитив.....	322,641.4	169,465.6	255,268.9	71.8
Ашиглаагүй зээлийн шугам.....	569,953.3	838,272.2	673,113.1	189.3
Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг.....	1,346,547.4	1,533,006.1	1,635,959.8	460.0

Банкны нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,346,547.4 сая төгрөгөөс даруй 13.8%-иар өсөж 2024 оны 12 дугаар сарын 31-ний бадлаар 1,533,006.1 сая төгрөг болсон бол цааш дахин 6.7%-ийн өсөлтийг үзүүлэн 2025 оны жилийн эцэс буюу 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,635,959.8 сая төгрөгт (460.0 сая ам.доллар) хүрсэн байна. Энэхүү өсөлтөнд голчлон аккредитив болон олгосон гүйцэтгэлийн баталгааны дүн нөлөөлсөн.

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүү байдлын тайланд тусгадаггүй ч тодорхой хэмжээний эрсдлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЛИЙН ТАЛААРХ ТООН БОЛОН ЧАНАРЫН МЭДЭЭЛЭЛ

Банк бизнесийн ердийн үйл ажиллагааны хүрээнд голчлон зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, хүүгийн эрсдэл болон гадаад валютын ханшийн эрсдэлд өртдөг.

Зээлийн эрсдэл

Банк нь зээлийн эрсдэлд өртдөг бөгөөд энэ нь санхүүгийн хэрэглүүрт нэг тал хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс нөгөө тал санхүүгийн алдагдал үүрэх эрсдэл юм. Банк оролцогч талуудтай зээлийн болон бусад ажил гүйлгээний үр дүнд зээлийн эрсдэлд өртөж, санхүүгийн хөрөнгө ба балансын гадуурх зээлтэй холбоотой үүрэг амлалтыг бий болгодог ба зээлийн эрсдэлд хамгийн их өртөх хэсэг нь санхүүгийн байдлын тайлан дахь санхүүгийн хөрөнгийн дансны үнээр тусгагдсан байдаг. Гаргасан санхүүгийн баталгаа, зээлийн шугам, экспорт импортын аккредитивийн үүрэг амлалтын хувьд зээлийн эрсдэлийн хамгийн их өртөх хэсэг нь нийт үүргийн дүн юм.

Зах зээлийн эрсдэл

Банк нь зах зээлийн эрсдэлд өртөх боломжтой хөрөнгүүдийг эзэмшдэг. Зах зээлийн эрсдэлд (а) валютын ханш, (б) хүүгийн түвшин, (в) өмчийн үнэт цаас, (г) бараа болон (д) бусад санхүүгийн хэрэглүүр (үүнд дериватив орсон) гэх зэрэг эрсдэлүүд ордог бөгөөд эдгээр нь банкны хөрөнгийн нээлттэй позиц болон тухайн хөрөнгөнд нөлөөлөх нийт болон ганцаарчилсан зах зээлийн хөдөлгөөнөөс үүсдэг. Банкны

удирдлага зах зээлийн эрсдэлийн гол хэмжигдэхүүнүүдийн хязгаарыг тогтоож, түүнийг өдөр бүр хянах байдлаар зах зээлийн эрсдэлийг удирддаг. Гэсэн хэдий ч, энэ нь зах зээлийн томоохон ач холбогдол бүхий үйл явдлуудын үед хязгаарлалтаас гадуурх алдагдлаас сэргийлэх боломжгүй юм. Иймээс Банк жил бүр хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө шинэчилдэг.

Гадаад валютын ханшийн эрсдэл

Зах зээл дээрх гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан банкны эзэмшиж буй гадаад валютын актив, пассивын үнэ цэнэ өөрчлөгдөж, банкны ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хэмжээнд нөлөөлж байвал гадаад валютын ханшийн эрсдэл гэнэ. Банкны санхүүгийн байдал болон мөнгөн гүйлгээ нь гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан эрсдэлд өртөмтгий байдаг. Аливаа валютын хувьд ханшийн эрсдэлээс хамгаалаагүй нээлттэй позиц нь банкны гадаад валютын ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байдаг. Гадаад валютын ханшийн эрсдэлийн тухайд удирдлага нь валютын өртөлтийн түвшинг хязгаарлаж, өдрийн болон шөнийн аль алинд нь нийт дүнгээр нь тогтоодог.

Хүүний түвшний эрсдэл

Банкны санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүгийн түвшний хэлбэлзлийн нөлөөнд өртдөг. Ийм хэлбэлзлийн үр дүнд хүүгийн ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх магадлалтай боловч гэнэтийн өөрчлөлт үүсэх тохиолдолд алдагдал буурах эсвэл эсрэгээрээ нэмэгдэх ч боломжтой. Банкны хүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь хүүгийн түвшний эрсдэлийн нөлөөллийг хязгаарлаж, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах замаар хүүгийн цэвэр орлого цаашлаад ашигт байдлыг нэмэгдүүлэх юм.

Банк хүүгийн эрсдэлд өртөж болзошгүй үндсэн шалтгаан нь татсан эх үүсвэрээс өөр ялгаатай дүн ба хугацаагаар, тогтмол хүүтэйгээр зээл олгох үйл ажиллагаатай холбоотой. Практик дээр богино хугацаанд хүү тогтмол байдаг. Мөн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг бодитой тусгахын тулд хөрөнгө болон өр төлбөрийн гэрээгээр тохиролцсон тогтмол хүүг дахин тохиролцох, өөрчлөх шаардлага үүсдэг. Банк боломжит хүүгийн эрсдэлийг тооцон хяналт тавьж, хүүгийн эрсдэлийг удирдах, бууруулахын тулд хязгаар тогтоох замаар хүүгийн эрсдэлийг удирддаг. Зөрүүгийн анализ (удирдлагын дүнтэй таарахгүй байх), хугацааны анализ (жинлэсэн дундаж дуусгавар болох хугацааны анализ) ба хүүгийн орлогын симуляци зэрэг аргыг хүүгийн эрсдэлийн түвшнийг тодорхойлоход ашигладаг. Үүнээс гадна банк нь хүүгийн зөрүүний удирдлага, хүүгийн эрсдэлийн хэджинг, тогтоогдсон хязгаарыг дагаж мөрдөх замаар эрсдэлийг удирдаж бууруулдаг. Хүүгийн хязгаарын процесс нь дараах зүйлсийг багтаадаг, үүнд (i) алдагдлын дээд хязгаар, (ii) хүүгийн зөрүүний хязгаар (iii) эх үүсвэрийг байршуулах хүүгийн хамгийн бага түвшин зэрэг байна.

Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд нь хүндрэл гарах үед үүсэх эрсдэлийг хэлдэг. Хоногийн хугацаатай хадгаламж, харилцах данс, хугацаа нь дуусгавар болж буй хадгаламжууд, зээлийн ашиглалт, баталгаа батлан даалт болон бэлэн мөнгөөр тооцоо хийдэг санхүүгийн үүсмэл хэрэглүүрүүдтэй холбоотойгоор бэлэн мөнгөний гарах урсгалын хэрэгцээ Банкны хувьд өдөр бүр гарч байдаг ч хугацаа нь дуусгавар болж буй эх үүсвэрийн тодорхой хувь нь гадагшлахгүй, хугацаа нь сунгагдах магадлал маш өндөр болохыг туршлагаас тогтоосон байдаг тул мөнгөний гарч болзошгүй гадагш урсгалын нийт дүнд хүрэлцэхүйц бэлэн мөнгөний нөөцийг Банкинд байнга хадгалдаггүй. Учир нь Банкны төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлага нь төлбөрийн чадварын эрсдэлийг хугацаагаар нь ангилан нэгтгэдэг бөгөөд хэвийн болон стрессстэй нөхцөл байдалд богино ба дунд хугацааны төлбөрийн үүргээ биелүүлэх чадвартай байхаар хөрвөх чадварыг удирддаг.

ИНФЛЯЦИЙН НӨЛӨӨ

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр хэрэглээний үнийн индексээр хэмжигдсэн жилийн инфляц 2023 онд 7.9%, 2024 онд 8.4%, 2025 онд 7.5% байсан бөгөөд Банкны бүх үйл ажиллагаа явагддаг Монгол Улсад инфляцийн түвшин нь банкны үйл ажиллагааны үр дүнд материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МАТЕРИАЛЛАГ БОДЛОГУУД

Банкны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын (СТОУС) дагуу бэлтгэж, түүхэн өртгийн суурьт тулгуурлан тооцоолон Монгол төгрөгөөр илэрхийлсэн болно.

Санхүүгийн хөрөнгө

Банк санхүүгийн хөрөнгүүдийн ангиллыг анхны хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлдог.

Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хэрэглүүрийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Гүйлгээний үнэ нь анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо болдог. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарз нь бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүд болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хүлээн зөвшөөрч, үр дүнг шууд бүртгэлийн гарзаар бүртгэдэг.

Ангилал болон дараа үеийн хэмжилт

Банк санхүүгийн хөрөнгүүдийг бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх, бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх болон хорогдуулсан өртгөөр хэмээн хэмжилтийн ангиллаар ангилдаг.

Дахин ангилал

Тухайн багцыг удирдах бизнес загвар нь бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийн дахин ангиллыг хийдэг. Дахин ангилал нь тухайн бизнес загвар өөрчлөгдсөнөөс хойш эхний санхүүгийн тайлангийн жилээс эхлэн хэрэгжинэ. Банк нь 2025 онд өөрсдийн бизнес загвартаа ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй болно.

ХБЗА-ын зээлийн алдагдлын сан

Банк нь хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон зээл, санхүүгийн баталгаатай холбоотой хүлээгдэж буй алдагдлыг ирээдүйн таамаглалын нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Банк нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (“ХБЗА”) хэмжиж, зээлжих эрсдэлийн хасагдуулгыг тайлант хугацаа бүрийн эцэст хүлээн зөвшөөрдөг. Доорх бүрэлдэхүүн хэсгүүд зээлийн алдагдлын санд голлох нөлөө үзүүлдэг:

- ХБЗА-ыг тооцоолох зорилгоор сегментчилсэн санхүүгийн хөрөнгүүд;
- ХБЗА-ы тухайн санхүүгийн хэрэгсэл тус бүрээр эсвэл багцын түвшин дэх үнэлгээг тодорхойлох;
- Банкны зүгээс тогтоосон дефолтын шалгуур тодорхойлолт;
- Зээлийн эрсдэлийн зэрэглэл бүрт дефолтын магадлалыг оноох дотоод үнэлгээний загваруудыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Санхүүгийн хэрэгсэл болон зээлтэй адилтгах хөрөнгийн үүргийн хувьд дефолт болох үеийн үлдэгдлийг (EAD) тооцоолох дотоод загваруудыг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Алдагдал хүлээх магадлалыг (LGD) үнэлэх, үүнд барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбоотой мэргэжлийн дүгнэлт, таамаглалууд;
- Зээлийн эрсдэл мэдэгдэхгүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд;
- Ирээдүйг харгалзсан макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох болон тэдгээрийн магадлалын жинг тогтоох.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дүн; (ii) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон (iii) тайлант хугацаа бүрийн эцэст өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн нөхцөл байдлын таамаглалын талаар хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээлэлд үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд ХБЗА-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Зээл болон санхүүгийн баталгааны хувьд ХБЗА-ын санг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрдөг. БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд ХБЗА-ын хасагдуулгыг хассан хорогдуулсан өртгийн өөрчлөлтийн дүн нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн бусад өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн гарзыг хассан дүнгээр олз гэж тайлагнагдана.

Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий дараах загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй зээлүүд нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын зээлүүдийн ХБЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЗА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэсгийн хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв Банк анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д шилжүүлэн ангилах бөгөөд ХБЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХБЗА). Хэрэв Банк санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "3-р шатлал" руу шилжүүлэн ангилах ба ХБЗА нь ашиглалтын хугацааны турш дахь хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Худалдан авсан, шинээр гаргасан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЗА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дахь ХБЗА-тай ижил хэмжигдэнэ.

Үүнээс гадна зээл болон ашиглаагүй байгаа зээлийн шугамыг хоёуланг нь багтаасан зээлийн карт гэх мэт санхүүгийн зарим хэрэглүүрүүдийн хувьд Банк хугацааны туршид хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тухайн хугацаа нь хамгийн ихдээ гэрээний хугацаатай адилхан болсон ч гэсэн зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр уг алдагдлыг багасгах хүртэл тооцоолдог. Эргэн төлөлтийг шаардах болон ашиглаагүй байгаа шугамын гэрээг цуцлах гэрээгээрх эрх нь гэрээний дагуу шаардах хугацаанд эрсдэлийн алдагдлын дүнд хязгаарлалт тавьдаггүйгэй холбоотой.

Санхүүгийн өр төлбөрүүд

Дараах үеэс бусад тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр ангилна. (i) бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн өр төлбөр: Энэ ангилал нь дериватив, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (жишээ нь. Үнэт цаасны богино позиц), бизнесийн нэгдлийн үед худалдан авагчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй төлбөр болон анхны хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлсон бусад санхүүгийн өр төлбөрүүд болон (ii) санхүүгийн баталгааны гэрээ ба зээлд хамаарах үүрэг багтана.

Орлого зардлын хүлээн зөвшөөрөлт

Хүүгийн орлого, зардлыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд бүх өрийн хэрэглүүр бүрийн хувьд аккруэль суурьт үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэрэглүүрийн хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцож орлого үр дүнгийн тайлангийн "Бусад адилтгах орлого" мөрөнд толилуулан.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцөлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. Банк нь харилцагчид зээл олгосны дараах богино хугацаанд тухайн зээлийг тусгайлсан хэлцэл байгуулах худалдах төлөвлөгөөгүй тохиолдолд тухайн зээлийг зах зээлийн хүүгээр олгохтой холбоотой

хураамж, шимтгэлийг үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцно. Зээл олгохоор хүлээсэн үүргийг Банк ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаггүй.

Үүссэн болон худалдан авсан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн түвшин нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (үүнд анхны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал орно) анх бодит үнэ цэнээр (худалдан авах үнээр илэрхийлэгддэг) хүлээн зөвшөөрөхдөө хямдруулах хүү юм. Үүний үр дүнд үр ашигт хүүгийн түвшин нь зээлийн тохируулгатай байдаг.

Дараах нөхцөлөөс бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг тооцоолно. Үүнд : (i) зээлийн үнэ цэнийн бууралтанд орсон санхүүгийн хөрөнгүүд (3-р үе шат), хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр тооцож, хүлээгдэж буй зээлийн алдагдлын санг хассан дүнгээр, (ii) үүссэн болон худалдан авсан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд анхны зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хорогдуулсан өртгийг тооцох үед тус тус байна.

Хэрэв 3-р үе шатанд ангилсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа нь сайжирч, хөрөнгө нь цаашид зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон мөн энэ сайжирсан байдал нь хөрөнгийг зээлийн үнэ цэнийн бууралттай гэж тогтоосны дараа үүсэх үйл явдалтай бодитойгоор холбоотой байгаа тохиолдолд хөрөнгийг 3-р үе шатнаас гаргаж, хүүгийн орлогыг дансны нийт дүнгээс үр ашигт хүүгийн аргаар тооцож бүртгэнэ. Өмнө нь хөрөнгө 3-р үе шатанд байсны улмаас ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан нэмэлт хүүгийн орлого нь ангилал сайжирснаар үнэ цэнийн бууралтын буцаалт гэж хүлээн зөвшөөрөгдөнө.

Хураамж, шимтгэлийн орлогыг харилцагч Банкны үйл ажиллагааны үр дүнд бий болсон үр өгөөжийг нэгэн зэрэг хүлээн авч, ашигладаг учраас үйлчилгээг үзүүлсэн үед нь шулуун шугамын аргаар хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Ийм орлогод засвар үйлчилгээний данс, үйлчилгээний хураамжийн данс, захиалгын төлбөрийн дансны хураамжууд, шимтгэл үйлчилгээний багцын төлбөр эсвэл гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс үйлчилгээний төлбөрийн шимтгэл хураамжийн орлогууд зэрэг багтана.

Хувьсах төлбөр хураамжийг томоохон хэмжээний буцаалт байхгүй гэдгийг өндөр магадлалтайгаар удирдлага тодорхойлсон үед л хүлээн зөвшөөрдөг.

Бусад хураамж, шимтгэлийн орлого нь ихэвчлэн үндсэн ажил гүйлгээ гарсны дараа тодорхой хугацаанд буюу Банк гүйцэтгэлийн үүргээ хангасан үед хүлээн зөвшөөрнө. Хүлээн авсан хураамж, шимтгэл болон авлагын дүн нь гүйцэтгэлийн ялгаатай үүргүүд гэж тодорхойлсон үйлчилгээний хувьд гүйлгээний үнийг илэрхийлнэ. Ийм орлогод харилцагчийн нэрийн өмнөөс гадаад валют худалдах, худалдан авахад зориулсан хураамж, төлбөрийн гүйлгээ хийх үйлчилгээний хураамж, бэлэн мөнгөний төлбөр тооцоо, цуглуулах, зарцуулах хураамж зэрэг багтана.

Гадаад валютын хөрвүүлэлт

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөөрх хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар бүртгэлийн суурь валютад хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг (гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз хасах гарз). Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй.